

**“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

2023.11.13

Д/д	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Биелэлт	Хувь
1.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийхийг бодлогоор дэмжинэ.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийхийг бодлогоор дэмжинэ	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийтийн орон сууц, таун хаус, амины орон сууц барих зориулалтаар газрыг бодлогоор дэмжин хамтран ажиллаж байна. Үүнд: - 315 айлын орон сууцны 1,8 га газар - 39 айлын нийтийн орон сууцны газар - 4 төрийн байгууллагын ажилчдын орон сууц барих 0,6 га газар - 49 айлын таун хаус барих 3,5 га газар - Сүмбэр суманд таун хаусын 0,66 га газрыг тус тус бодлогоор дэмжин олгож ажилласан.	100%
2	Жуулчны отог бааз, амралтын газар шинээр байгуулах санал санаачилгыг дэмжиж, жуулчны баазын чанар стандартыг хангуулах, дэд бүтцийг бий болгох чиглэлээр зээлийн дэмжлэг үзүүлнэ.	Жуулчны бааз байгуулах саналыг бодлогоор дэмжиж ажилласан байна. Үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз амралтын газрын газрын тоо-1 Жуулчны баазын дэд бүтцийг бий болгох чиглэлээр зээлийн дэмжлэг үзүүлнэ. 2 жил үйл ажиллагаа явуулаагүй аялал жуулчлалын зориулалттай газрыг хүчингүй болгоно	Аймгийн хэмжээнд 3 сумдаас 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд жуулчны отог бааз, амралтын газар шинээр байгуулахаар иргэн, хуулийн этгээдээс санал ирээгүй болно. Мөн эзэмшиж буй газраа зоиулалтын дагуу ашиглаагүй аялал жуулчлалын зориулалттай 7 газрын судалгааг гарган хүчингүй болгох ажлыг хуулийн дагуу зохион байгуулахыг Сүмбэр, Шивээговь сумдын Засаг дарга нарт 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/104 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч одоог хүртэл тухайн шатны Засаг дарга нар ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.	70%

3	Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ	Сүмбэр сумын 1-р багт дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх зураг төсвийн гүйцэтгэл 100 хувь	-Дахин төлөвлөлтийн ажлын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг “Жаргалант хийц” ХХК-тай 18,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэж, хүлээлгэн өгөх шатандаа байна. -Барилга, хот байгуулалтын яамтай хамтран ажиллаж байгаа Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн үнэлгээг хэрэгжүүлж буй зөвлөх баг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Говьсүмбэр аймагт ажилласан. Уулзалтын санал дүгнэлтээр дахин төлөвлөлт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн гадна инженерийн шугам сүлжээний бэлтгэл ажил, инженерийн дэд бүтэцийн асуудлыг эхний ээлжинд шийдвэрлэх, судалгаа шинжилгээний ажлыг нарийвчлан гаргах, дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зэрэг асуудлыг тодотгосон. 2023 онд дахин төлөвлөлтийн ажлын төлөвлөлтийн зураг төслийг боловсруулж дуусахад цахилгааны техникийн нөхцөл олгох асуудал шийдвэрлэгдэхгүй хугацаа алдсан боловч БЗӨБЦТС ТӨХК-ийн Чойр салбараас техникийн нөхцлийг олгохоор зөвшилцөлд хүрч, техникийн нөхцөл авах шатандаа байна. Байгууллагын зүгээс төслийн судалгааны ажил, зураг төслийн төлөвлөлтийн зургийг хянах ажилд хамтран ажилласан. Хүрсэн түвшин: Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийн явц 90 хувьтай.	70%
4	Орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг дэд бүтэц болон газрын бодлогоор дэмжинэ	Орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг бодлогоор дэмжинэ.	Аймаг, орон нутагт орон сууц хаус хороолол барих санал санаачлагыг газрын бодлогоор дэмжин 7 төрийн байгууллагад 65672м2 газрыг орон сууц, хаусын зориулалтаар аймаг, сумын Засаг даргын захирамжаар олголт хийн ажилласан байна. Үүнд: ❖ Аймгийн Засаг даргын 2018 оны А/126 тоот захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газар Сүмбэр сумын Найрамдал багийн Хөжил хотхонд 49 айлын хаусын зориулалтаар 35000м2 газар; ❖ Аймгийн Засаг даргын 2019 оны А/257 тоот захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газар Сүмбэр сумын Найрамдал багийн Найрамдал хотхоны 33 тоотод 315 айлын орон сууцны зориулалтаар 18000м2 газар; ❖ Аймгийн Засаг даргын 2021 оны А/420 тоот захирамжаар Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газарт Сүмбэр сумын Найрамдал багийн Гомбосүрэн ноёны өргөн чөлөө 2-216	100%

			таун хаусын зориулалтаар 6672м2 газар; ❖ Аймгийн Засаг даргын 2022 оны А/146 тоот захирамжаар аймгийн Онцгой байдлын газарт Сүмбэр сумын Ган зам багийн Баянхайрхан 3-326 тоотод 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалтаар 1500м2 газар; ❖ Аймгийн Засаг даргын 2022 оны А/61 тоот захирамжаар аймгийн БЗӨБЦТС ТӨХК-д Сүмбэр сумын Ган зам багийн Баянхайрхан 3-328 тоотод 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалтаар 1500м2 газар; ❖ Аймгийн Засаг даргын 2022 оны А/319 тоот захирамжаар аймгийн ШШГА-ны хорих 425 дугаар нээлттэй хорих ангид Сүмбэр сумын Ган зам багийн Баянхайрхан 3-330 тоотод 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалтаар 1500м2 газар; ❖ Аймгийн Засаг даргын 2023 оны А/163 тоот захирамжаар аймгийн Шүүхийн Тамгын газарт Сүмбэр сумын Ган зам багийн Баянхайрхан 3-334 тоотод 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалтаар 1500м2 газар;	
5	Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбож, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.	Сүмбэр сумын 3-р багт гэр хороололд цэвэр усны шугам татна. Шинээр сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон өрхийн тоо - 20	Сүмбэр сумын ОНХС-ийн 139.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Тагтын эгнээд ф150мм-н цэвэр усны хуванцар хоолой 580м, ухаалаг худаг 1ш гаргах ажлыг “Ус-Ду” ОНӨААТҮГ гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Цэвэр усны шугамын ажил хийгдсэнээр 438 айл өрх цэвэр усаар хангагдах боломж бүрдсэн. -Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 87.1 сая төгрөгийн хөрөнгөөр 300м цэвэр усны шугамын ажлыг “Такамаса” ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтанд хүлээлгэн өгсөн. Цэвэр усны шугамын ажил хийгдсэнээр 80 айл өрх цэвэр усаар хангагдах боломж бүрдсэн. - БХБЯ-ны захиалгатай Сүмбэр сумын 1 дүгээр багийн айл өрхийн бохир усыг төвлөрсөн бохир усны шугамд холбох ажлыг “Мөнхзүмбэр” ХХК 700,0 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэж байна. 2022 оны ажлын гүйцэтгэл 100% хийгдсэн. 2023 онд нийт 1200м бохирын шугамын ажил, өргөх станцын ажлууд хийгдсэн. Нийт ажлын гүйцэтгэл 80 хувьтай. Дээрх инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэнээр Хүрсэн түвшин: 518 айл өрх цэвэр усаар хангагдах боломжтой юм. -70 ААН, 408 айл өрхийн бохир усыг татан зайлуулах боломжж бүрдсэн.	100%

6	540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	120 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлнэ	Сүмбэр сум 3 дугаар багт 315 айлын орон сууц бариулахаар орон нутгаас газрын асуудлыг бодлогоор дэмжиж 1,8 га газрыг шийдвэрлэсэн. Мөн орон сууцны гадна цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд “Шинээр баригдах хотхоны гадна цахилгаан хангамж 6кв ЦДАШ, 2Х630 кВа хаалттай дэд өртөө”-ний ажлыг орон нутгийн төсвийн 240,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Осо-констракшн” ХХК гүйцэтгэж байна. 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар дэд өртөөний засал, тоноглолын ажлыг хийх материал татан авалтын ажил хийгдэж байна. Цахилгаан хангамжийн ажилд 100% захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүрсэн түвшин: Цахилгаан хангамжийн ажил 90%	100%
7	Нар болон салхины сэргээгдэх эрчим хүч бий болгоход бодлогоор дэмжинэ	Дэмжлэг авсан аж ахуйн нэгжийн тоо-1	Аймаг, орон нутагт нар болон салхины сэргээгдэх эрчим хүч бий болгох санал санаачлагыг газрын бодлогоор дэмжин 5 хуулийн этгээдэд 286,6 га газрыг нарны цахилгаан станцын зориулалтаар сумын Засаг даргын захирамжаар олголт хийн ажилласан байна. Үүнд: - Сүмбэр сумын Засаг даргын 2018 оны А/242 тоот захирамжаар “Том нар энерги” ХХК-д нарны цахилгаан станцын зориулалтаар 50га газрыг; - Сүмбэр сумын Засаг даргын 2020 оны А/12 тоот захирамжаар “Элгэн монгол мед” ХХК-д нарны цахилгаан станцын зориулалтаар 50га газрыг; - Сүмбэр сумын Засаг даргын 2016 оны А/61 тоот захирамжаар “Сан степпе” ХХК-д эрчим хүчний станцын зориулалтаар 100га газрыг; - Сүмбэр сумын Засаг даргын 2019 оны А/247 тоот захирамжаар “И Эс Би Солар Энержи” ХХК-д эрчим хүчний станцын зориулалтаар 29,6га газрыг; - Сүмбэр сумын Засаг даргын 2021 оны А/239 тоот захирамжаар “Ю Пи Си Чойр лэнд холдингс” ХХК-д эрчим хүчний станцын зориулалтаар 1га газрыг; - Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны А/276 тоот	100%

			захирамжаар “Ю Пи Си Чойр лэнд холдингс” ХХК-д эрчим хүчний станцын зориулалтаар 56га газрыг Дээрх аж ахуйн нэгжээс одоогийн байдлаар И Эс Би Солар энерги ХХК нь сэргээгдэх эрчим хүчний зориулалтаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нарнаас авсан эрчим хүчийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д нийлүүлэн ажиллаж байна. Ю Пи Си Чойр лэнд холдингс ХХК нь туршилтын станцыг бий болгон салхины хурдыг тогтмол хэмжин ажиллаж байна.	
8	Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих бүтээн байгуулалтад мэдээ мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлэх	Мэдээллээр хангасан тоо-5	2022 онд Орос, Хятад, Монгол улсын хэлэлцээрийн хүрээнд «Союз восток» хий дамжуулах хоолойн ажилд орон нутгаас хамтран ажиллах ажлын хэсгийг байгуулан мэдээлэл солилцон ажиллаж байгаа бөгөөд 2023 онд аймгийн Засаг даргын 2023 оны А/244 захирамжаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. “Газ пром” НХН-д Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх хэсэгт барилгын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай инженерийн иж бүрэн судалгаа хийх зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2022 оны А/117 тоот захирамжаар олгосон. Мөн аймгийн Засаг дарга “Газпром” НХН-тай нууцлалын гэрээ байгуулсны үндсэн дээр ажлын хэсгийн нарийн бичиг “Газпром” НХН-ээс хийн хоолойн трассын файлыг хүлээн авсан. Хийн хоолойн трассын дагуух “Инженер экологи”-н судалгааны ажлыг гүйцэтгэгч Жэмр ХХК-ний 2022 оны 66 дугаар тоот албан бичгийн дагуу хий дамжуулах шугам хоолойн трассын дагуу 2км радиуст хамрагдаж буй иргэн, хуулийн этгээдийн эзэмшил газар болон худгийн мэдээллийг байгууллагын 2022 оны 01/263 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. “Газопровод союз восток” ХХК-иас ирүүлсэн хий дамжуулах хоолойн тэнхлэгээс нь 2 тийш 500 м өргөнтэй зурвас хэсэгт олгогдсон газруудын судалгааг мөн гарган тус тус хүргүүлж хамтран ажиллаж байна.	100%
9	Төрийн үйлчилгээг цахимжуулж, тоон гарын үсгийг нэвтрүүлж, иргэдэд сурталчилна.	Цахимжуулсан төрийн үйлчилгээний тоо -10 И-Монголиа холбосон системд төрийн	-Газартай холбоотой цахимжуулсан төрийн үйлчилгээний тоо-57 -Барилгын салбарын 5 төрлийн үйлчилгээ -И-Монголиагаар 17 төрлийн лавлагаа -Тоон гарын үсгээр үйлчилдэг төрийн үйлчилгээний цахим систем-2 -Албаны тоон гарын үсэг ашиглаж буй төрийн албан хаагч-12 -Иргэний тоон гарын үсэг авсан албан хаагч-13	100%

		үйлчилгээний тоо -70 Тоон гарын үсгийг нэвтрүүлсэн төрийн үйлчилгээний тоо –38 Тоон гарын үсгийг ашиглаж байгаа төрийн албан хаагчийн тоо – 100 Тоон гарын үсэгтэй болгосон иргэний тоо –5000 Зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, хамрагдсан иргэний тоо -90	Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд: - Газрын удирдлагын цахим системүүд /8 төрлийн/ -egazar.gov.mn -geoportal.gov.mn -MLE.mn -urban.gov.mn веб системүүдээс гадна киоск машинаар дамжуулан төрийн үйлчилгээг цахимжуулан ажиллаж байна. 2023 оны байдлаар 57 төрлийн үйлчилгээг цахим системүүдээрээ үзүүлж байна. Үүнээс гадна e-mongolia төрийн нэгдсэн цахим системээр дамжуулан газартай холбоотой 17 төрлийн лавлагааг олгон ажиллаж байна. Мөн байгууллагын цахим хуудас болон өдөр тутмын “Зууны мэдээ” сонингоор дамжуулан иргэд олон нийтэд мэдээ мэдээллийг ил тод нээлттэй хүргэн ажиллаж байна.	
10	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газруудад Иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулан, операторын системийг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Операторын системээр хүргэсэн төрийн үйлчилгээг тогтвортой нэмэгдүүлнэ. Шинээр барьсан өргөтгөлийн барилгын тоо - 1 Хүчин чадал - 150	Аймгийн нэг цэгийн үйлчилгээний хэсэгт “Газрын харилцааны-Цахим үйлчилгээ”-ний өрөөг тохижуулан иргэд цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэн принтер, компьютер, сканнерыг байршуулсан. Газрын кадастрын цахим киоски машин авахаар аймгийн орон нутгийн хөгжил санд 20 сая төгрөгний төсвийг батлуулан орон нутгийн өмчийн албаар худалдан авах тендерийг зарлуулж авсан.	100%
11	Цэцэрлэгийн барилгуудыг өргөтгөж, шинээр барина. (3 болон 5 дугаар цэцэрлэг)	Шинээр барьсан өргөтгөлийн барилгын тоо - 1 Хүчин чадал - 150	1.Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр “Монничи Кон Трейд”ХХК шалгарч ажлыг гүйцэтгэж байна. 2023 онд 600,0 сая төгрөг батлагдсан. Жилийн эцсийн байдлаар 1,2 дугаар давхарын өрлөг, дээвэр, гадна цахилгаан, фасадны ажил хийгдээд байна. Ажлын гүйцэтгэл 60%-тай. 2.Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг	100%

			төслийг 35,0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Цээнтэй ателиер” ХХК зураг төслийг гүйцэтгэсэн. 2024 оны улсын төсөвт 120 ортой цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 3 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй баригдахаар тусгагдсан. 3.Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн тус бүр 150 хүүхдийн 2 цэцэрлэгийн барилгын 1 барилга ашиглалтад орж, 1 барилгын гүйцэтгэл 80 хувьтай байна. Байгууллагын зүгээс дээрх ажлуудад 100% захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрхи барилга угсралтын ажлуудад байгууллагаас 100% захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүрсэн түвшин: Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэл -60 хувь Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл – 80 хувь	
12	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны их засварын ажлыг үе шаттайгаар хийнэ.	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны их засварын ажлыг үе шаттайгаар хийнэ	2022 онд Шивээговь сумын 3 дүгээр цэцэрлэг болон 5 дугаар цэцэрлэг, 5 дугаар сургуулийн биеийн тамирын талбайн засварын ажлыг хийх ажлын тоо хэмжээг гаргахад байгууллагын БХБХ-ийн дарга болон ахлах мэргэжилтэн нар хамтран ажиллаж, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан. 2023 онд: - Шивээговь сумын 3-р цэцэрлэгийн гадна хашааны ажлын төсөвт өртөг тооцох -Сүмбэр сумын 5-р сургуулийн спорт залны дулаалгын ажил зэрэгт мэргэжлийн зөвлөгөө өгч, хамтран ажилласан. -Баянтал сумын 4 дүгээр сургуулийн спорт залны 600м2 дээвэр засварын ажлыг “”Цагаан толгойн нуур” ХХК 100% гүйцэтгэсэн. Хүрсэн түвшин: -Шивээговь сумын 3-р цэцэрлэгийн хашааны ажлын төсөвт өртөг: 159,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тооцогдсон. -5-р сургуулийн спорт залны дулаагын ажил 59,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр тус тус тооцогдсон.	100%

БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

№	Арга хэмжээний тоо	Үүнээс						Биелэлтийн хувь
		100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь	30хувь	0 хувь	Арга хэмжээний үнэлгээ
1.	12	10	-	2	-	-	-	95%

ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГА

Б.ОТГОНЧИМЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН: АЖИЛТАН

Т.УРАНТОГОС